



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/80

Баруун хараа

Угийн бичиг хөтлөх олон нийтийн санаачлагыг  
дэмжих салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.6, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан "Угийн бичиг хөтлөх журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд угийн бичиг хөтлөх олон нийтийн санаачлагыг дэмжих салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга	Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Соёлын төвийн дарга
Гишүүдэд	Хараа 1 дүгээр багийн Засаг дарга
	Баян 2 дугаар багийн Засаг дарга
	Гонир 3 дугаар багийн Засаг дарга
	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Соёлын төвийн Номын санч

2. Угийн бичиг хөтлөх салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


3. Салбар зөвлөлд даалгах нь:

а/ Сумын хэмжээнд угийн бичиг хөтлөх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

б/ Угийн бичиг хөтлөх олон нийтийн санаачлагыг өрнүүлэн аян, уралдаан тэмцээн, сургалт сурталчилгаа, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулан ажиллах

4. Багийн иргэдэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулан, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэн ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Эрдэнэбаатар)-т даалгасугай.



Р.БАТЖАРГАЛ

Захирамж-А-2022 он